



ГАРЧИГ

1–3	Бодлогын нийтлэл
4–6	Зохицуулалтын мэдээ
7–8	Тайлбар зөвлөмж
9–10	Тогтвортой санхүүжилт
11–12	Комплайнсын хяналтыг хэрхэн нэвтрүүлэх вэ?
13–14	Финтек ба регтек
15–19	Судлаачийн индэр
20–21	Виртуал хөрөнгийн талаар таны мэдэх ёстой зүйлс
22–23	Олон улсын зах зээлийн мэдээ
24	Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН БРОКЕР, АГЕНТЫГ “ҮНДЭСНИЙ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СТАНДАРТ”-Д ХАМРУУЛЛАА

Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжих шилжилтийн үндэс болсон анхдугаар Үндсэн хуулиа 1992 онд баталж, Монгол Улсын иргэн хөрөнгө эзэмших, өмчлөх, захиран зарцуулах эрхтэй болсноор үл хөдлөх хөрөнгийн салбар манай улсад үүсэж хөгжих үндэс суурь тавигдсан. Үүнээс хойших хугацаанд төрөөс улс орны нийгэм, эдийн засагт ач холбогдол бүхий тус салбарыг хөгжүүлэхээр хууль эрх зүйн орчныг бүрдүүлсээр иржээ. Тухайлбал, 1998 оны Барилгын тухай хуулиар барилгын үйл ажиллагаа эрхлэх, материал үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих болон ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг, 2002 оны Иргэний хуулиар үл хөдлөх хөрөнгийн талаарх ерөнхий зохицуулалт, эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой харилцааг, 2002 оны Газрын тухай хууль болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар газар өмчлөх, ашиглах, эзэмшихтэй холбогдсон харилцааг, 2003 оны Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэж, баталгаажуулахтай холбогдон үүсэх харилцааг тус тус зохицуулжээ.

Барилгын салбар хөгжсөнөөр үл хөдлөх хөрөнгө болон түүнтэй холбоотой эрхийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага иргэд, олон нийтийн дунд үүссэнээр 2007 онд анхны үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагууд Монгол Улсад бүртгэгдсэн байна. Улмаар төрөөс аливаа хяналт, зохицуулалтгүйгээр хөгжиж буй тус салбарыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй салбар хэмээн Санхүүгийн хориг арга хэмжээг авах байгууллага (цаашид “ФАТФ” гэх) дүгнэснээр 2018 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн нэмэлтээр “МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГ”-тэй этгээдэд тус салбарт оролцогч байгууллагуудыг хамруулсан юм.



Үргэлжлэл 2-р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

CORPORATE BOND – КОМПАНИЙН БОНД

Компани нь тодорхой хэмжээний мөнгийг санхүүгийн байгууллагаас буюу хувь хүнээс зээлсэн, түүнийгээ ирээдүйд тодорхой нөхцөлийн дагуу төлөхийг амласан өрийн бичиг.

BOND – БОНД (ӨРИЙН БИЧИГ)

Янз бүрийн хөрөнгө оруулагчдаас (зээлдүүлэгчдээс) мөнгөн хөрөнгө татахын тулд бизнесийн байгууллага болон засгийн газраас гаргадаг урт хугацаат өрийн хэрэгсэл.

BOND EQUIVALENT YIELD – БОНДТОЙ АДИЛТГАСАН ЖИЛИЙН ХҮҮ

Бондтой адилтгасан жилийн энгийн хүүгийн (өгөөжийн) хувь.

BOND INDENTURE – БОНДЫН ГАРГАЛТЫН НӨХЦӨЛ

Бондыг гаргасан нөхцөлийг заасан эрх зүйн баримт бичиг.



Эх сурвалж: Хөрөнгийн зах зээлийн нэр томъёоны тайлбар толь

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН БРОКЕР, АГЕНТЫГ “ҮНДЭСНИЙ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН СТАНДАРТ”-Д ХАМРУУЛЛАА

Эхлэл нь 1-р нүүрт

Улмаар 2020 онд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулан зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчилсан. Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр улсын бүртгэлийн байгууллагад хандан 6,728 хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааг бүртгэлээс хасуулж, 2020 оны 4 дүгээр сараас 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд 311 хуулийн этгээдэд дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоод байна. Эдгээр зуучлалын байгууллагууд нь 2023 оны эхний хагас жилд 469 хувьцаа эзэмшигчийн 6.7 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 324 брокер болон 1,269 агенттайгаар үйл ажиллагаа эрхэлж байна.

Тус салбарт оролцогчдыг анх төрийн хяналт зохицуулалтад хамруулсан үе буюу 2020 оны эхний хагас жилд 103 хуулийн этгээдийн нийт хөрөнгө 8.0 тэрбум төгрөг байсан бол энэ оны эхний хагас жилд 311 хуулийн этгээд 198.5 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна. Энэ нь салбарын оролцогчид 3 дахин нэмэгдэж,

нийт хөрөнгийн хэмжээ 24.6 дахин өссөн үзүүлэлт юм.

Мөн 2023 оны эхний хагас жилд зохицуулалттай этгээдүүд нь давхардсан тоогоор 7,463 хэлцлээр 939.7 мянган м.кв талбай бүхий үл хөдлөх хөрөнгийг 1.0 их наяд төгрөгөөр худалдах, худалдан авах, хөлслөх, хөлслүүлэх, түрээслэх, түрээслүүлэх үйл ажиллагаанд зуучлан 26.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого олсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэлцлийн тоо 1.4 дахин, талбайн хэмжээ 1 дахин, үнийн дүн 1.6 дахин өсжээ. Дээр дурдсанчлан үл хөдлөх хөрөнгийн зуучлалын салбарт оролцогч байгууллагуудын цар хүрээ нэмэгдэхийн хэрээр технологийн дэвшлийг ашиглан үл хөдлөх хөрөнгийн цахим зуучлал, цахим дуудлага худалдаа, үл хөдлөх хөрөнгийн түрээсийн цогц үйлчилгээ зэрэг технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж эхэлсэнтэй холбогдуулан салбарын статистик тоон мэдээллийг дэлгэрүүлэх, зайны хяналт шалгалтыг хялбаршуулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 235 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг шинэчлэн баталж, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны актын бүртгэлд бүртгүүлээ.

Түүнчлэн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа нь мэргэжлийн арга зүй дээр тогтдог тул салбарын мэргэжилтнүүд мэргэшлийн ёс зүйг баримталж, мэргэжлийн түвшинд ажилласнаар салбарын нэр хүнд өсөн нэмэгддэг онцлогтой. Иймд салбарын оролцогчдыг чадавхжуулах, тэдгээрийн нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлох, хариуцлагажуулах ажлын хүрээнд үл хөдлөх хөрөнгийн мэргэжилтэн болох брокер, агентыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 03 тоот тогтоолоор Үндэсний ажил мэргэжлийн стандартад хамруулан индексжүүлж, батлуулсан.

Мөн салбарын оролцогчдыг чадавхжуулах, мэргэшсэн байдлыг хангах зорилгоор үл хөдлөх хөрөнгийн салбарын мэргэжилтэнд эрх олгох сургалтыг 2023 оны эхний хагас жилийн байдлаар 10 удаа зохион байгуулж, салбарын 613 оролцогчийг хамруулаад байна.

З о х и ц у у л т т а й
этгээдүүдэд мөнгө угаах
болон терроризмыг
санхүүжүүлэхтэй тэмцэх
гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх, мэдээлэх
үүрэгтэй этгээдийн
үүргээ биелүүлэхэд
шаардлагатай мэдээлэл,
зөвлөмжүүдийг хүргэх
зорилгоор “Үл хөдлөх
хөрөнгийн бизнес
эрхлэгчдийн дээвэр
нэгдсэн холбоо”



ГҮТББ, Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба болон “Санхүүгийн боловсролын зангилаа” ГҮТББ-тай хамтран үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын оролцогчдод “Комплайнсын эрсдэлийг удирдахуй” нээлттэй хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан.

Тус хэлэлцүүлгийн үр дүнд олон улсын стандартад нийцсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан аргачлалыг салбартаа үр дүнтэйгээр хэрэгжүүлэх, мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулах замаар комплайнсын эрсдэлийг удирдах, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангахад төр, хувийн хэвшил нэгдсэн ойлголттой болсон бөгөөд ФАТФ-ын зөвлөмж,

стандартыг биелүүлэхэд салбарын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд томоохон ач холбогдолтой үйл явдал болсон юм.

Цаашид олон улсын сайн туршлагыг судалж, дотоодын зах зээлийн онцлогт нийцүүлэн үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарт шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх хүрээнд холбогдох ажлуудыг хийж байна. Тухайлбал, Орон сууцны тухай хуулийн 71.1.4 дэх заалт, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын 3.2-ыг үндэслэн Барилга, хот байгуулалтын яам, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын хэрэгжүүлж буй “Орон сууцны

мэдээллийн сангийн цахим хуудсыг хөгжүүлэх” ажилд Санхүүгийн зохицуулах хороо нь Барилга, хот байгуулалтын яамны төслийн багтай хамтран үл хөдлөх хөрөнгийн салбарын статистик мэдээллийг бодит цагийн горимоор бүрдүүлэх ажлыг хийж эхэлсэн бөгөөд тус мэдээллийн нэгдсэн сан бүрдсэнээр тусгай зөвшөөрөлтэй зуучлалын байгууллагуудын холбогдох мэдээлэл болон зуучлалын

мэдээний датаг тус системээс тухай бүр авах, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээлэл, байршлын судалгааг харах зэрэг боломжууд бүрдэх бөгөөд уг системд Монгол Улсын үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой бүхий л мэдээлэл агуулагдах онцлогтой юм.

Мөн Жендэрийн эрх тэгш байдлын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх болон “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах стратеги төлөвлөгөө” (2022–2031), жендэрийн бодлого, олон улсын гэрээ, конвенцуудыг хэрэгжүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх явцад салбарын хэмжээнд хүйс, нас, боловсрол зэргээр ангилсан өгөгдөл болон жендэрийн статистик мэдээллийг цуглуулах, баяжуулах, бодлого төлөвлөлт, журмуудад тусгах, холбогдох сургалтад хамруулах зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

АСЕАН+3 БОНДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ОЛОН УЛСЫН ФОРУМ БОЛЛОО



Азийн хөгжлийн банк, БНСУ-ын Санхүүгийн үйлчилгээний хороо болон тус улсын Үнэт цаасны хадгаламжийн байгууллагаас хамтран зохион байгуулсан АСЕАН+3 бондын зах зээлийн олон улсын форум Пусан хотноо боллоо. Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (АСЕАН) болон БНХАУ, Япон, БНСУ-ын сангийн сайд нар хамтран Азийн бондын зах зээлийн санаачилга (АБЗЗС)-ын хүрээнд форумыг анх санаачилсан бөгөөд АСЕАН+3 бодлогын хэлэлцүүлэгт авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, зөвлөмжийг тайлагнадаг цорын ганц бүс нутгийн платформ юм. Тодруулбал хил дамнасан бондын гүйлгээтэй холбоотой зохицуулалт, зах зээлийн практик, зах зээлийн дэд бүтцийг стандартчилах, уялдуулах замаар АСЕАН+3 зах зээлийг нэгтгэх зорилготой бөгөөд гишүүн орнуудын зохицуулагч, дэд бүтцийн байгууллагууд болон олон улсын байгууллагуудын төлөөлөл, эрдэмтэн, судлаач, мэргэжилтнүүд тогтмол оролцдог.

38 дахь удаагаа болж буй энэ удаагийн форумд Монгол Улсаас Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамны холбогдох албаныхан оролцож өөрийн орны хөрөнгийн зах зээлийн хөгжил, өнөөгийн нөхцөл байдал, цаашдын бодлого, зохицуулалтын арга хэмжээ, үндэсний валютаар арилжаа хийдэг дотоодын бондын зах зээл сэдвээр тус тус илтгэл тавилаа. Түүнчлэн гишүүн орнуудын зохицуулагч, дэд бүтцийн болон олон улсын байгууллагуудын төлөөлөлтэй хөрөнгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын орчны талаар санал солилцов. Мөн энэ үеэр БНСУ-ын Санхүүгийн үйлчилгээний хороо болон дэд бүтцийн байгууллагаас солонгосын хөрөнгийн зах зээлийн хөгжил, зохицуулалтын орчныг таниулах, бондын зах зээлийн хөгжил,

нүүрстөрөгчийн ялгарлыг цэвэр дүнгээр тэг (net-zero) байлгах, байгаль орчинд ээлтэй ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих хүрээнд хэрэгжүүлсэн ажил, бүс нутгийн хамтын ажиллагааны ач холбогдол, туршлагаасаа хуваалцсан юм.

Манай улсын хувьд АСЕАН+3 бондын зах зээл форумд 2019 оноос хойш идэвхтэй оролцож ирсэн бөгөөд 2021 онд Азийн хөгжлийн банктэй хамтран АСЕАН+3 бондын зах зээлийн цуврал гарын авлагыг боловсруулж гаргасан. Энэхүү гарын авлага нь бонд гаргагч, хөрөнгө оруулагчид болон санхүүгийн зуучлагчдад тухайн улсын дотоодын нөхцөл байдлыг ойлгоход нь туслах, бүс нутгийн хурдацтай хөгжиж буй бондын зах зээлд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой билээ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН ХҮРТЭЭМЖТЭЙ, НОГООН САНХҮҮГИЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭГЭЭ ТАНИЛЦУУЛАВ



Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс зохион байгуулж буй “Санхүүгийн тогтвортой, хүртээмжтэй хөгжил, цэцэглэлтийн төлөө-2023” Дэлхийн бодлогын форум Филиппин улсын Манила хотноо зохион байгуулагдлаа. Хуралдаанаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, бодлогын тэргүүлэх чиглэлээ тодорхойлох, гишүүн орнуудын санхүүгийн салбарыг тогтвортой хөгжүүлэх, ногоонжуулах, санхүүгийн хүртээмжийн ялгааг арилгах сайн туршлагын талаар санал солилцохын зэрэгцээ Филиппиний Төвбанк болон бусад гишүүн орны санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд үр өгөөжөө өгсөн санал, санаачлагын талаар илтгэл хэлэлцүүлээ.

Мөн энэ үеэр “Уур амьсгалын өөрчлөлтэй нүүр тулж буй жижиг, дунд бизнес эрхлэгчид” салбар хуралдаан болж Монгол Улсыг төлөөлөн оролцож буй Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Фижи Улсын Төвбанкны ерөнхийлөгч Ариф Али, Манлайлал хөтөлбөрийн захирал Сара Буитони, Филиппиний арлын банкны Стратеги, санхүүгийн захирал Эрик Роберто М.Лучанго нарын хамт панелистаар оролцлоо. Нийт 50 гаруй орны 150 гаран төлөөлөгч энэхүү салбар хуралдаанд оролцож жижиг, дунд үйлдвэрлэлийг ногоон чиглэлээр хөгжүүлэх, ногоон бодлогыг дэмжих арга зам болон санхүүгийн зохицуулагч байгууллагуудын үүрэг оролцоог хэрхэн нэмэгдүүлэх талаар хэлэлцсэн юм. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан энэ үеэр Монгол Улс тэр дундаа Санхүүгийн зохицуулах хорооноос хүртээмжтэй, ногоон санхүүгийн салбарыг хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, санал санаачилга, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид ногоон санхүүжилт авахад тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга зам, туршлага, цаашдын хөгжлийн талаар танилцуулахад хуралд оролцогчид мөн гишүүн байгууллагууд дээрх туршлага, арга замаас судлах, санал солилцохоо онцолсны зэрэгцээ цаашид энэ чиглэлд хамтран ажиллахаа илэрхийллээ.

Түүнчлэн энэ өдөр “Эмэгтэйчүүд, залуучууд, ЖДҮ-ийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэхэд төрийн хувийн хэвшлийн хамтын ажиллагаа” сэдвийн хүрээнд удирдлагуудын дугуй ширээний уулзалт болж санхүүгийн зохицуулагч байгууллага, төв банкны буюу гишүүн байгууллагуудын удирдлагууд, хувийн хэвшлийнхний төлөөлөл оролцож санал бодлоо солилцлоо. Үүний зэрэгцээ нийт төлөөлөгчид “Хиймэл оюун ухаан”, “Залуу бизнес эрхлэгчид”, “Дижитал санхүүгийн үйлчилгээг хурдасгах нь”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх” гэсэн дөрвөн дэд хэсэгт хуваагдаж залуу бизнес эрхлэгчид, бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарт тулгарч буй санхүүгийн хүртээмжийн бэрхшээлийг инноваци, шинэ санал санаачилгын тусламжтайгаар хэрхэн бууруулах, шийдвэрлэх арга зам, Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн бодлого, тулгуур зарчмуудтай хэрхэн уялдуулах талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН ХУРАЛ ЭХЭЛЛЭЭ

Олон улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (Alliance for Financial Inclusion)-ийн Дэлхийн бодлогын форум “Санхүүгийн тогтвортой, хүртээмжтэй хөгжил цэцэглэлтийн төлөө-2023” сэдвийн дор Бүгд Найрамдах Филиппин Улсад 9 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулагдаж байгаа бөгөөд

Монгол Улсыг төлөөлж Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны дарга Д.Баярсайхан болон төлөөллийн хамт оролцож байна. Филиппиний Төв банкт хамтран зохион байгуулж буй тус форумд 60 гаруй орны санхүүгийн зохицуулагч байгууллага, төв банкны төлөөлөл болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн 700 гаруй төлөөлөгчид оролцож нийгэм, эдийн засгийн



хөгжилд үзүүлж буй Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (СХН)-ийн үйл ажиллагааг технологийн хөгжлийг ашиглаж хүн бүрт ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст хэрхэн хүргэх талаар хэлэлцэв. Түүнчлэн, хурлаар өнгөрсөн оны ажлаа дүгнэхийн зэрэгцээ ирэх онд анхаарч ажиллах үндсэн чиглэлийг баталж, нийгэмлэгийн үйл ажиллагааны статусыг өргөжүүлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлэх юм. Хурлын үеэр зохион байгуулагдсан Санхүүгийн хүртээмжийн стратеги”, “Дижитал санхүүгийн үйлчилгээ” зэрэг нийт 7 ажлын хэсэг тус бүрийн хуралд СЗХ-ны төлөөлөгчид оролцож санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, түүний шийдэл, сайн туршлагын талаар байр сууриа илэрхийлж, санал солилцлоо.

Санхүүгийн зохицуулах хороо нь нийгэмлэгийн Захирлуудын зөвлөлд 2 удаа, Зүүн Европ, Төв Азийн бүсийн санаачлагын даргаар 2021-2023 онд сонгогдон ажилласан бөгөөд энэ хугацаандаа зах зээлийн хөгжлийн чиг хандлагад тулгуурлан бүс нутгийн онцлогт тохирсон бодлого зохицуулалтын шинэ санал, санаачилга дэвшүүлэн ажилласныг гишүүн орнуудын зүгээс өндрөөр үнэллээ.

“МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ” ХХК ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГАА ЭХЛҮҮЛЛЭЭ

“МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны цан цохих ёслол боллоо. Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун, “Монголын хөрөнгийн бирж”



ХК-ийн бизнес, хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, “МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Л.Ганзоригт, ТУЗ-ийн гишүүн Б.Тэлэнгэд, гүйцэтгэх захирал Г.Хишигбат, үндсэн андеррайтер “Мандал капитал маркетс ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Мөнхтуяа, туслах андеррайтер “Инвескор капитал ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Билгүүн болон холбогдох албаны бусад хүмүүс оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун ёслолын арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, зах зээлд оролцогчдын оролцоог нэмэгдүүлэх, цаашлаад хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр бодлого зохицуулалтын олон ажлуудыг эрчимтэй хэрэгжүүлж байгаагийн нэгэн чухал ажил нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг дотоодын зах зээлд оруулах юм. Өөрөөр хэлбэл хамгийн суурь хүчин зүйл болсон зах зээл дээрх чанартай бүтээгдэхүүнүүд, засаглал сайтай компаниудыг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд энэ хүрээнд Хорооноос төрийн өмчит компаниудыг хувьчлах, ТОП-100 аж ахуй нэгжийг олон нийтийн компани болгох зэрэг дотоодын аж ахуйн нэгжээс нийтэд санал болгон хувьцаагаа гаргах, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татахыг дэмжин

ажиллаж, холбогдох хууль, журмыг шинэчлэн сайжруулж байна.

Түүнчлэн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компаниудын үйл ажиллагаа явуулж буй салбарыг төрөлжүүлэх замаар эдийн засгийн салбаруудыг дэмжих нь хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бас нэгэн чухал алхам болохын хувьд Монгол Улсын эдийн засгийн салбарууд дундаас экспортын орлогыг нэмэгдүүлэх, импортын бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой байлгахад чухал ач холбогдолтой тээвэр, логистикийн салбарт 18 жил үйл ажиллагаа явуулсан, салбарын томоохон төлөөлөл “МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ” ХХК хувьцаат компани болж байгаад баяртай байна.

Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагуудаас хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах сонирхол нэмэгдэж, үүнийг даган зах зээлд шинэ бүтээгдэхүүнүүд ихээр гарч, хөрөнгө оруулагчдад сонголт өргөн болж байгаад баяртай байгаагаа илэрхийлээд дахин баяр хүргэе.” хэмээн онцолсон юм.

Тус компани нийт хувьцааныхаа 15 хувийг нэгж бүрийг нь 185 төгрөгөөр олон нийтэд санал болгож 10.98 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх бөгөөд нийтэд санал болгож буй хувьцааны 70 хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, 30 хувийг олон нийтэд санал болгож байгаа аж.

ТАЙЛБАР ЗӨВЛӨМЖ

“ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ”–ЫН ТАЛААР

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”–ыг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 23–ны өдрийн 235 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, тус журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

Дээрх журмаар үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт шалгалт хийж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын хэрэгжилт, учирч болзошгүй эрсдэлийн түвшнийг тодорхойлж, түүнд үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Мөн тус журмыг зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдээс ирүүлбэл зохих үндсэн үйл ажиллагаатай холбоотой зуучлалын мэдээний загварыг сайжруулж, статистик тоо мэдээг баяжуулах, зайны хяналт, шалгалтыг хялбаршуулах улмаар шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэх зорилгоор шинэчлэн найруулж дараах гол өөрчлөлтүүдийг тусгасан. Үүнд:

ЖУРАМД ОРСОН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД:

Хасаж найруулсан зохицуулалтууд:

- 1) Хорооны 363 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”–ын 5 дугаар бүлэгт тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулсныг Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь заалтад “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэсэн заалттай нийцүүлэн хассан.
- 2) Журмын 2.2.3–т “үндсэн үйл ажиллагаа, санхүү төлбөрийн чадварыг нь сайжруулах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгөх” гэсэн заалт нь журмын 2.3 дахь заалттай агуулгын хувьд давхцаж байх тул хассан.
- 3) Журмын 3.3–т “Удирдамжид шалгалтын зорилго, үндэслэл, шалгалтын төрөл, хүрээ, шалгалтад хамрагдах зуучлалын байгууллагын нэр, шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн,

шалгалт эхлэх болон дуусах хугацааг тусгана” гэж заасан нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалттай давхцаж байх тул хасаж найруулсан.

- 4) Журмын 3.6.9–3.6.11 дэх заалтууд нь Хорооны 2023 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”–тай агуулгын хувьд давхцаж байх тул хассан.

3.6.9. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан томилсон шийдвэр;

3.6.10. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан дотоод хяналтын хөтөлбөр, эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийн хэрэгжилт;

3.6.11. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээ, сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг хуульд заасан хугацаанд Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн талаарх баримт)

- 5) Журмын 7 дугаар хавсралтад заасан “Мэдээлбэл зохих гүйлгээ, харилцагчийн бүртгэлийн мэдээ” нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам”–ын 5.1 дэх заалттай тус тус зөрчилдөж байх тул хассан.

Холбогдох хууль тогтоомжид хариуцлагын арга хэмжээг заасан байх тул журмын төслөөс хариуцлагын талаарх зохицуулалтыг хасаж найруулсан.

Нэмж тусгасан зохицуулалтууд:

- 1) Хяналт шалгалтын төрөл, хэлбэрийг тусгайлсан бүлэг болгож, өөрчилсөн.
- 2) Журмын 1.2–т “Хорооноос баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”–аар зуучлалын байгууллагын

үйл ажиллагаанд хийх хяналт шалгалттай холбоотой нийтлэг харилцааг зохицуулж, энэ журмаар нарийвчилсан харилцааг зохицуулна” гэсэн заалтыг нэмсэн.

- 3) Журмын 1.4-т “Хороо хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ “Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалтын бодлогын баримт бичиг”-т заасан зарчмыг баримтална” гэсэн заалтыг нэмсэн.
- 4) Журмын 4.9-д “Газар дээрх хяналт шалгалт хийхэд зуучлалын байгууллагын эрх бүхий албан тушаалтныг байлцуулах бөгөөд тухайн албан тушаалтан ирээгүй нь уг шалгалтыг хойшлуулах үндэслэл болохгүй” гэсэн заалтыг нэмсэн.
- 5) Журмын 4.11-т “Газар дээрх хяналт шалгалтын дүнд илэрсэн зөрчил, дутагдалд шалгалтын тайлангаар болон Улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, шаардлагатай тохиолдолд зөрчлийн хэрэг нээх, эсхүл гэмт хэргийн шинжтэй тохиолдолд харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлнэ” гэсэн заалтыг нэмсэн.
- 6) Журмын тавдугаар хавсралтад “Санхүүгийн тайлангийн тодруулга”-ыг нэмсэн.
- 7) Тайлан нэгтгэлийн Фин-А систем нь хязгааргүй тайлан (VCT)-ийн нэгтгэлийг гаргах боломжгүйгээс хянан шалгагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлсэн тул зайны хяналт, шалгалтыг хялбаршуулж, салбарын статистик тоо мэдээллийг баяжуулах зорилгоор журмын зургаадугаар хавсралт буюу “зуучлалын байгууллагын үндсэн үйл ажиллагааны мэдээлэл”-д зуучлалын байгууллагуудаар дамжуулан зуучлуулсан үл хөдлөх хөрөнгүүдийг талбайн хэмжээгээр ангилсан. (0-50 м.кв, 51-100 м.кв, 101-200 м.кв, 201 м.кв-аас дээш)
- 8) Түүнчлэн, барилгын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй эсэх, барилгын компанийн хараат, охин, зэргэлдээ компани эсэх, компанийн нэгдэл эсэх, ногоон барилга, байгууламжийн төсөлтэй хамтран ажиллаж байгаа эсэх, Цахим технологи (платформ, аппликэйшн) ашиглан үйл ажиллагаа эрхэлдэг эсэх, дотоод хяналтын ажилтны мэдээлэл, зөвшөөрөл авснаас хойш холбогдох дүрэм журмуудад өөрчлөлт орсон эсэх (хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэм гэх мэт), ажилтнуудыг чадавхжуулж, сургалтанд давтан хамруулсан эсэх, холбооны гишүүнчлэлтэй эсэх, зуучлалын мэдээ гаргасан ажилтны утасны дугаар зэрэг мэдээллийг тайлагнахаар нэмж тусгасан.

- 9) Журмын долоодугаар хавсралт буюу “үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах, шилжүүлэх үйл ажиллагааны зуучлалын мэдээ”-ний загварт дараах мэдээллийг тайлагнахаар нэмж тусгасан. Үүнд:

- ◆ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн харилцагчийг таньж мэдэх үүргийн хэрэгжилтийн хүрээнд итгэмжлэлээр төлөөлж буй эсэх талаар мэдээлэл;
- ◆ Зуучлалын байгууллагууд зөвхөн зуучлалын гэрээ байгуулсан харилцагч талыг мэдээлэхээр журамласныг худалдсан, худалдан авсан хоёр талын мэдээллийг хамтад нь тайлагнахаар журмын төсөлд нэмж тусгасан;
- ◆ Зуучлалын мэдээний загварт салбарын статистик тоо гаргах зорилгоор ипотекийн зээлд хамрагдсан эсэх мэдээлэл зэрэг болно.

- 10) Нийт зуучлалын байгууллагаар дамжин худалдаалагдаж буй үл хөдлөх хөрөнгийн 85.6 хувийг орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө эзэлдэг тул статистик тоон мэдээллийг үнэн зөв бүрдүүлэхийн тулд журмын зургаадугаар хавсралтад үл хөдлөх хөрөнгийн төрлийг орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө (тансаг зэрэглэлийн амины орон сууц, нийтийн орон сууц, зуслангийн байшин, хашаа байшин) болон бусад үл хөдлөх хөрөнгө (үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө, арилжааны зориулалттай үл хөдлөх хөрөнгө, газар, автозогсоол) гэж ангилсан.

- 11) Журмын долоодугаар хавсралт буюу “үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг түрээслүүлэх, түрээслэх, хөлслөх, хөлслүүлэх үйл ажиллагааны зуучлалын мэдээ”-ний загварын дагуу зуучлалын байгууллагууд зөвхөн харилцагч талын мэдээллийг тайлагнадаг байсныг өөрчилж, түрээслэгч (түрээслүүлэгч), хөлслөгч (хөлслүүлэгч) хоёр талын мэдээллийг хамтад нь тайлагнахаар нэмж тусгасан.

Өөрчлөн найруулсан зохицуулалт:

- 1) “Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн нэгдсэн сангийн журам”-ын хугацаатай нийцүүлэн журмын 5.1-д “Зуучлалын байгууллага нь санхүүгийн тайланг улирал бүр гаргаж, улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар болон албан бичгээр ирүүлнэ” гэж өөрчлөн найруулсан.
- 2) Зуучлалын байгууллагуудаас санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр авдаг байсныг улирал бүр тайлагнахаар өөрчлөн журамлаж, тайлангийн загваруудыг хавсралтад нэмж тусгасан.

ТОГТВОРТОЙ САНХҮҮҮЖИЛТ

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ /БОНЗ/-ЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Тоон мэдээлэл нь бүх нөхцөл байдлын шинжилгээний үндэс суурийг бүрдүүлдэг. Энэ нь тухайн байгууллагад одоогийн байр сууриа тодорхой харж, боломжуудыг нээж, аюул заналыг илрүүлэх боломжийг олгодог.

Уур амьсгалын өөрчлөлт ба тогтвортой байдал нь байнга хөндөгддөг сэдэв бөгөөд байгууллагууд тогтвортой байдлын үйл ажиллагаагаа хэрхэн удирдаж, тайлагнаж байгаадаа анхаарлаа хандуулах нь зүйтэй билээ.

Компаниуд байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын ил тод байдлын шаардлагуудыг төлөвлөх шаардлага улам бүр нэмэгдсээр байгаа бөгөөд заавал дагаж мөрдөх уур амьсгал, БОНЗ-ын шинэ тодруулгууд нь дагаж мөрдөх чухал хэмжигдэхүүнийг нэмж байна. Өсөн нэмэгдэж буй дижитал орчинд тоон өгөгдөл нэн чухал болж байна. БОНЗ-ыг заавал дагаж мөрдөх, зохицуулалт хийх онцлогтой салбаруудад өндөр чанартай тоон өгөгдөл нь шаардлагад нийцсэн үйл ажиллагаа болон үнэтэй торгуулийн хоорондох ялгааг илэрхийлдэг. Өсөн нэмэгдэж буй хатуу зохицуулалтууд нь таньж мэдэх, эх сурвалжаас авахаас эхлээд нэгтгэх, төвлөрүүлэх, мэдээллийн аюулгүй байдал, дүн шинжилгээ хийх, тайлагнах хүртэлх үйл явцын бүх үе шатанд илүү сайн мэдээллийн менежментийг шаардах болно.

Зөв өгөгдлийг цуглуулснаар компанийн үлдсэн үйл явц нь логиктой бөгөөд ойлгомжтой болно. Гэсэн хэдий ч буруу мэдээлэл цуглуулбал бүх үйл явц нуран унах эрсдэлтэй.

БОНЗ тоо мэдээлэл сайн цуглуулсны 7 ашиг тус:

1. Компанийн өөрийн эргэн тойрон, үйл явц дахь хяналтыг бэхжүүлэх;
2. Бизнесийн өсөлтийг хангах, компанид үнэ цэнийг бий болгох;
3. Чиг хандлага, эрсдэл, боломжуудыг тодорхойлох чадварыг олгох;
4. Бүх талын тайланг гаргахад хөнгөвчлөх;
5. Ач холбогдолтой таамаглалыг дэвшүүлэх;
6. Аудитыг хялбар, амар, цаг хугацаа бага зарцуулдаг болгох;
7. Тайланг эцсийн хугацаандаа багатаан эцэслэхэд туслах.



БОНЗ-ын тоо мэдээлэл цуглуулахад ямар бэрхшээл тулгардаг вэ?

БОНЗ-ын тоо мэдээлэл нь олон хэлбэртэй байж болох бөгөөд олон эх сурвалжаас бий болно. Өгөгдөл нь байнга эсвэл үе үе авахаар, бүтэцтэй эсвэл бүтэцгүй байж болох бөгөөд мөн өөр өөр системд, янз бүрийн форматаар, янз бүрийн хүмүүстэй компанийн өгөгдөл байж болно.

Энэхүү асар олон янз байдал нь өгөгдөл нь утга учиртай, ашиглах боломжтой, тайлагнахад хялбар байхын тулд үүнийг даван туулах шаардлагатай мэдээллийн чанарын сорилтод хүргэдэг.

Сайн чанартай, ашиглах боломжтой өгөгдөл цуглуулахад тулгарч буй бусад бэрхшээлүүд нь:

- ◆ Авах боломжгүй байдал;
- ◆ Тохиромжгүй байдал (жишээ нь буруу формат);
- ◆ Бүрэн бус байдал;
- ◆ Хүртээмжгүй байдал;
- ◆ Мэдээлэл авахдаа хүний буруутай үйлдлээс шалтгаалсан алдаа;
- ◆ Буруу тооцоолох боломж;
- ◆ Өгөгдлийг авахад цаг хугацаа их шаардагдах байдал;
- ◆ Хамгаалалтын зохих арга хэмжээ аваагүйн улмаас өгөгдөл нь алдагдах эрсдэлтэй.

Компаниуд БОНЗ-ын тоо мэдээллийг хэрхэн үр дүнтэй цуглуулах вэ?


Мэдээллийг үр дүнтэй цуглуулж, БОНЗ-ын амжилттай удирдлагын үндэс суурийг тавихын тулд компаниуд хэд хэдэн

алхмуудыг дагаж болно.

- ◆ Тодорхойлох: Цуглуулж буй тодорхой тоо мэдээллийг тодорхойлж, цуглуулах шалтгааныг баталгаажуулах;
- ◆ Байршуулах: Тоо мэдээллийн эх сурвалжийг олж, түүний чанарыг хэрхэн үнэлэх талаар бодож үзэх;
- ◆ Төвлөрүүлэх: Мэдээллийг найдвартай, хүртээмжтэй, аудит хийх боломжтой байдлаар хэрхэн нэгтгэхийг шийдэх;
- ◆ Шинжилгээ хийх: Тоо мэдээллийг сайтар судалж, чанарыг шалгах;
- ◆ Үүсгэх: Тайланг эмхэтгэж, сонирхогч талуудад түгээх.

Автомат болон гар аргаар цуглуулах БОНЗ–ын тоо мэдээлэл

Гар аргаар /manual/ БОНЗ–ын тоо мэдээлэл цуглуулах арга нь хүмүүс тоо мэдээллийн эх сурвалжийг хянаж, өөрсдийн

Гар аргаар болон Автомат аргаар цуглуулсан тоо мэдээлэл**БОНЗ–ын хамгийн түгээмэл тоо мэдээллийн хэмжүүрүүд юу вэ?**

- ◆ Хүлэмжийн хийн ялгаруулалт – жишээ нь: Хамрах хүрээ 1, Хамрах хүрээ 2, Хамрах хүрээ 3 ялгаралтын мэдээлэл;
- ◆ Ажилчдын оролцоо – жишээ нь: Ажилчдын санал асуулга, хариулт;
- ◆ Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ – жишээ нь: Эрчим хүчний хэрэглээний хэдэн хувийг ногоон эрчим хүчний эх үүсвэрээс авдаг вэ?;
- ◆ Ажилтай холбоотой гэмтэл – жишээ нь: Осол, гэмтэл, нас баралтын тоо, гэмтлийн улмаас алдсан хоног, урт хугацааны гэмтлийн давтамж;
- ◆ Ажиллах хүчний хэмжүүрүүд – жишээ нь: Компанийн олон талт байдал. Хэдэн хувь нь эмэгтэйчүүд вэ?;
- ◆ Цэвэр шинээр ажилд авсан хүмүүс болон халагдсан хүмүүсийн хувь хэмжээ – жишээ нь. Шинээр ажилд орсон болон компаниас гарсан ажилчдын тоо.

ашигладаг аливаа мэдээллийн зохион байгуулалтын хэрэгсэлд гараар (ихэвчлэн Excel хүснэгт) өгөгдлийг цуглуулахыг хэлнэ.

Дижитал технологи гарч ирж, нийтэд түгээмэл болж байгаа хэдий ч олон байгууллага гар аргаар мэдээлэл цуглуулах арга барилд найдсан хэвээр байгаа бөгөөд энэ нь цаг хугацаа, хөдөлмөр их шаарддаг арга юм.

Автоматжуулсан БОНЗ–ын тоо мэдээлэл цуглуулах арга нь шаардлагатай бүх мэдээллийн эх сурвалжтай суурилуулсан програм хангамжийг ашиглан автоматаар хийгддэг. Эх сурвалж бүрт шинэ тоо мэдээлэл нэмэгдэх тусам автоматаар хуримтлагдсан програм хангамжийн платформ руу шилжиж, дүн шинжилгээ хийхэд бэлэн болно. Тоо мэдээллийг бодит цаг хугацаанд нэмдэг тул дүн шинжилгээг ихэвчлэн хамгийн сүүлийн үеийн мэдээллийн багц дээр хийж, нөхцөл байдлын харагдах байдлыг сайжруулж, үйл ажиллагааны болон стратегийн шийдвэр гаргахад тусалдаг.



Хүлэмжийн хийн ялгаруулалт



Ажилчдын оролцоо



Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ



Ажилтай холбоотой гэмтэл



Ажиллах хүчний хэмжүүрүүд



Шинээр орсон болон халагдсан хүмүүс

Эх сурвалж: <https://www.isometrix.com/blog/esg-data-collection/>

БАЙР СУУРЬ

КОМПЛАЙНСЫН ХЯНАЛТЫГ ХЭРХЭН НЭВТРҮҮЛЭХ ВЭ?

«Комплайнс» гэх англи хэлнээс гаралтай үгийг хууль тогтоомж, эсхүл компанийн дотоод дүрэм, журам зөрчигдөхөөс сэргийлэх зорилготой багц арга хэмжээ гэж тодорхойлж болно. Комплайнс нь ямар эрсдэлээс хамгаалдаг болон комплайнсын хяналтыг нэвтрүүлэх ажлыг хэн зохион байгуулах ёстой талаар Санхүүгийн зохицуулах хорооны компанийн засаглал, комплайнсын хэлтсийн дарга А.Авиртай ярилцлаа.

Комплайнсыг салбар бүрд мэргэжилтнүүд өөрийнхөөрөө тайлбарлах явдал ажиглагддаг, иймд нэгдсэн ойлголтыг уншигчдад өгвөл?

Одоогоор манай орны хууль тогтоомжид «комплайнс» гэсэн нэр томъёоны тодорхойлолт алга. Миний хувьд комплайнс гэж бизнесийн үйл ажиллагааг хууль тогтоомж, ёс суртахуунд нийцүүлдэг компанийн засаглалын нэгээхэн хяналтын хэрэгсэл гэж ойлгодог.

Үндсэн зорилго нь ирээдүйд санхүүгийн алдагдалд орох, эсвэл нэр хүнд унах эрсдэлийг бууруулах юм. Өөрөөр хэлбэл, үйл ажиллагаандаа хууль тогтоомжийг дагаж мөрдөх, ажил үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн стандартыг баримтлах тухай ойлголт. Иймээс комплайнс гэдэг тодорхойлолт дан ганц хууль тогтоомжоор хязгаарлагдахгүй нийгмийн хариуцлага, олон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлс, шударга байдал, ёс суртахууны асуудлыг хамардаг.

Товчхондоо, хууль бус болон ёс бус үйлдээс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль тогтоомжид нийцсэн байгууллагын соёлыг бий болгох гэж ойлгож болно.

Ямар байгууллагууд комплайнсын хяналтыг нэвтрүүлэх шаардлагатай вэ?

Миний бодлоор компани болгон комплайнсын хяналтыг нэвтрүүлэх шаардлагатай. Учир нь аливаа компанийн ажилтан бүр хууль тогтоомж болон байгууллагын дотоод дүрэм, журмыг шингээсэн комплайнсын стандартуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Зарим байгууллагад дотоод хяналт болон комплайнс нь бизнес эрхлэхэд төдийлөн ач холбогдолгүй гэж үзээд тэдгээрт цаг хугацаа, хөрөнгө зарцуулах сонирхолгүй талдаа байдаг бол зарим компанийн жишээн дээр чанартай комплайнс хяналт нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлдгийг практик дээр харуулсаар байна.

Энэ нь үйлчлүүлэгчдийн эерэг хандлага, зан төлөв, хөрөнгө оруулагчдын сонирхол, хувьцаа эзэмшигчдийн компанид итгэх итгэл, нийгмийн хандлага зэргээр илэрхийлэгддэг. Тухайлбал, олон улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаасаа санал болгож буй компаниудын хувьд өөрийн комплайнс тогтолцоотой байх нь тухайн орны зохицуулагч байгууллага болон мэргэжлийн институционал хөрөнгө оруулагчдын зүгээс нааштай эерэг үнэлгээ өгөх суурь нь болдог.

Мөн үр дүн бүхий комплайнс хяналтын тогтолцоо нь хөрөнгө оруулах сонирхол, санхүүгийн болоод үйл ажиллагааны найдвартай байдлын түвшинг дээшлүүлдэг байна. Нөгөө талаас АНУ (Foreign Corrupt Practices Act 1977), ИБУИВУ (UK Bribery Act 2010) зэрэг орнуудын хууль эрх зүйн орчин нь гадаадын компани өөртөө үр дүн бүхий комплайнсын нэгжтэй байхыг чухалчлан шаарддаг.

Одоогоор манай улсын хувьд хөрөнгийн зах зээл, даатгалын салбарын оролцогчид болон гадаадын зах зээлд түшиглэн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь комплайнсын хяналтыг эхний ээлжинд нэвтрүүлэх зорилтот бүлгүүд болоод байна.

Байгууллагын хийх гэж буй үйл хөдлөл, шийдвэрийг комплайнсын хяналтаар шалгах энэ тогтолцоо нь удаан хугацаанд амжилттай явах итгэл найдварыг бизнес эрхлэгчдэд бий болгодог байна.

Эсрэг тохилдолд комплайнсын дараах эрсдэлүүд зохицуулалттай бизнесийн байгууллагад үүсч болно:

- ◆ Гүйлгээний данс хаагдах, царцах;
- ◆ Төлөвлөгөөт бус газар дээрх хяналт шалгалт хийгдэх;
- ◆ Захиргааны арга хэмжээ, торгууль тавигдах;
- ◆ Үйл ажиллагаа нь хэсэгчлэн, эсхүл бүрэн зогсох;
- ◆ Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл нь түдгэлзэх, цуцлагдах;
- ◆ Төлбөрийн чадваргүй болох;
- ◆ Нэр хүнд нь унах гэх мэт.

Комплайнсын хяналт хэрэгжсэнээр ямар эрсдэлийг удирдах боломжтой вэ?

Манай орны хувьд аж ахуйн нэгжүүд өөрсдийн үйл ажиллагаагаа сайжруулах үүднээс нийгмийн хариуцлага, хүний нөөцийн болон эрсдэлийн удирдлага, дотоод хяналт зэрэг компанийн засаглалын олон хэрэгслүүдийг нэвтрүүлж эхлээд удаагүй, комплайнсын хяналтын тогтолцоо хөгжлийнхөө эхэн шатандаа байна. Харин хөгжингүй орнуудын хувьд энэхүү тогтолцооны олон хэлбэрүүд бизнесийн бүх салбаруудад нэгэнт хэвшээд эхэлжээ.

Комплайнсын эрсдэл гэвэл зохицуулалтын нөхцөл, шаардлагын хүрээнд учирч буй зөрчил, албан тушаалаа урвуулан ашиглах,

эсхүл авлигын үйлдэл, мэргэжлийн болон ёс бус үйлдэл, гуравдагч этгээдийн хууль бус үйлдэл зэргээс шалтгаалан үйл ажиллагаа нь доголдох, зогсох, бизнесийн нэр хүнд унах, санхүүгийн чадамжгүй болох зэрэг юм. Эдгээр эрсдэлээс болж материаллаг, цаг хугацааны, оюуны өмчийн, мэдээллийн, хүний нөөцийн, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль, экологи, байгууллагын нэр хүнд зэрэгт хор хохирол учирч болно.

Гэхдээ байгууллага бүр өөрийн эрсдэлээ илрүүлж, тодорхойлсноос хамаарч өндөр эрсдэлтэй бизнес процесс дээрээ ач холбогдол өгч, анхааран ажиллах хэрэгтэй.

Харин маш бага орлоготой, цөөн тооны ажилтантай жижиг компанийн хувьд?

Комплайнсын хяналтыг нэвтрүүлэх буюу жишээлбэл авлига, залилангийн үйлдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах нь тухайн байгууллагын ажиллагсдын тоо, зохион байгуулалтын хэлбэр, орлогын хэмжээ, үйл ажилагааны далайц, салбарын онцлог зэргээс үл хамаардаг ба комплайнсыг хэрэгжүүлэх нь ажилтан бүрийн үүрэг, хариуцлага юм.

Тэгвэл жижиг компанийн хувьд комплайнсын хяналтын хэрэгслүүдийг бүрэн нэвтрүүлэх шаардлагатай юу?

Тэгэх шаардлага байдаггүй. Учир нь комплайнсын зорилго бол үр дүнтэй байх, тэрнээс биш амьдрал дээр хэрэгждэггүй олон журам, заавартай, эсхүл бизнесээ хэт хяналтаар боомилсон байх нь зохимжгүй.

Комплайнсын хяналтыг нэвтрүүлэх ажлыг юунаас эхлүүлэх вэ?

Практик дээр үүнийг хэрэгжүүлэхэд удирдлагын манлайлал хамгийн чухал, удаах нь комплайнсын хяналт эрх зүйн болон санхүүгийн хувьд хараат бус бие даасан байдлыг хангасан байх шаардлагатай. Үүний тулд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, хэрэв байхгүй бол үүсгэн байгуулагч, эсвэл гүйцэтгэх удирдлага нь комплайнсын нэгж, эсхүл ажилтныг томилохтой зэрэгцэн комплайнсын журам, заавар, жилийн зардлын төсвийг батална.

Улмаар байгууллагын болон ажилтны хувь хүний үйлдлүүдтэй хамааралтай хууль тогтоомж, дүрэм, журмын жагсаалтыг гаргаад, тухайлан хамаатай зүйл тус бүрээр нь жагсаадаг. Жишээлбэл: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар аж ахуйн нэгж нь замын хөдөлгөөний соёл, мэргэжлийн ур чадвар, ёс зүйн харилцааны зохицуулалтыг байгууллагын дотоод дүрэм, журамд тусган, хэрэгжилтийг хангах ёстой бол хувь хүн Замын хөдөлгөөний дүрмийг мөрдөх үүргийг хүлээх жишээтэй.

Мөн ёс зүйн дүрмийг салбарын эрх зүйн орчинд нийцүүлэн шинээр боловсруулах, эсхүл сайжруулах шаардлага үүснэ. Үүнд эрх бүхий албан тушаалтан ба ажилтнуудын чиг үүрэг, мэргэжлийн харилцааны хэм хэмжээний стандартуудыг тогтоох гэх мэт. Мөн шинэ ажилтнууд болон нийт албан хаагчдад тогтмол мэдээлэл өгч байх жилийн сургалтын хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх нь зохистой.

Цаашдаа байгууллагын дотоод үйл ажиллагаандаа дагаж мөрдөх

бодлого, дүрэм журам, аргачлалаа байнга шинэчлэж байх хэрэгтэй болдог.

Комплайнсын хяналт үр дүнтэй байна гэдгийг яаж мэдэх вэ?

Маш энгийн, хэрэв комплайнсын хяналтын бүтцийг бий болгоход хүргэсэн зорилтууд биелэгдсэн тохиолдолд тэрээр үр дүнтэй ажиллаж байна гэсэн үг.

Удирдлагын зүгээс тайлант хугацаанд хэдий хэмжээний зөрчлүүд илэрсэн, тэдгээрээс хэдийг нь удирдаж чадсан талаар байнга дүгнэлт хийхээс гадна ажилтнууд байгууллагын дотоод дүрэм, журмын талаар мэдлэг, мэдээлэлтэй байгаа эсэхийг байнга хянах ёстой.

Энэ ажил нь тухайн байгууллагын комплайнсын хяналтын нөхцөл байдал, үр дүнг үнэлэхэд тустай.

Комплайнсын хяналтыг цахимжуулах талаар мэдээлэл өгнө үү?

Комплайнсыг бүрэн цахимжуулах талаар ярих эрт байна, учир нь комплайнсыг хэрэгжүүлэхэд хиймэл оюун ухаан бус хүний мэдрэмж их чухал шаардлагатай байдаг. Тиймээс одоогоор автоматжуулах хандлага эрчимтэй явагдаж байна.

Хүний боловсруулах, шинжилж, дүгнэлт гаргах мэдээллийн тоо хэмжээ хязгаарлагдмал байдаг. Гэтэл комплайнсын ажилтны хариу үйлдэл үзүүлэх шаардлагатай сэрэмжлэх мэдээллийн тоо тогтмол өсч, ажын ачаалал нэмэгдсэн боловч нөөц үргэлж дутагдаж байдаг.

Тэгэхээр ажлын ачаалал гэх сорилтыг автоматжуулалтаар шийдэх боломжтой. Тогтмол боловсруулалт хийх, шинжилж, дүгнэх шаардлагатай асар их мэдээллийн боловсруулалтыг автоматжуулах буюу хүний оролцоог багасгаж, үр дүнг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг стандартчилах, мэдээллийн сан үүсгэх зэрэг шийдлүүд зах зээлд бий болсон.

Харин төсөв хангалтгүйг шийдэхийн тулд зарим компани эрсдэлээ ач холбогдлоор нь буюу хамгийн чухал, яаралтай шийдэх шаардлагаар нь үнэлээд эхэлсэн. Ихэнх нь комплайнсын хяналтын үндсэн чиглэлээр “шүгэл үлээгч”-ийн тогтолцоог сонгосон байдаг. Энэ нь мэдээлэл харилцааны сувгийг ашиглан болзошгүй зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, хариу үйлдэл үзүүлэх үйл явц.

Энэ үйл явцыг автоматжуулснаар хэн нэгэн ямар ч төхөөрөмжөөс орон зайнаас үл хамааран мэдээлэл солилцох, харин комплайнсын ажилтан тухайн болзошгүй зөрчлийн мэдээллийг нэгдсэн загвар бүхий маягаар хүлээн авахаас гадна түүнийгээ статистик мэдээллийн санд оруулан бүх янзаар боловсруулж ашигладаг. Болзошгүй зөрчлийн тухай мэдээлэл нь ирсэн цаг хугацаа болон зөрчлийн хэлбэрээр ангилагдаж, улмаар холбогдох албан тушаалтанд хүргэгддэг. Энэ нь мэдээллийн санд цугларах зөрчлийн мэдээлэл, гарсан шийдвэрүүдэд мониторинг хийх, элдэв тайлан боловсруулахад нэн тустай.

Тэгэхээр ажлын ачаалал их, нөөц хангалтгүй зэрэг сорилтуудыг зохион байгуулалтын шийдэл болон үндсэн чиглэлээ ач холбогдлоор нь үнэлж, байгаа төсвөө хуваарилснаар шийдвэрлэх бүрэн боломж харагдаж байна.


ФИНТЕК БА РЕГТЕК

2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ДЭЛХИЙН ФИНТЕКИЙН САЛБАРЫН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын сүлжээ байгууллага болох KPMG-ээс гаргадаг “Pulse of Fintech” финтекийн салбарын тойм 2023 оны 7 дугаар сард нийтлэгдсэн бөгөөд 2022 оны сүүлийн хагас жилийн байдлаар 63.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт 2,885 хэлцэл хийгдсэн бол, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 52.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтаар 2,153 хэлцэл хийгдэж буурчээ. Америк тивд


финтекийн санхүүжилт өсөж, 2022 оны сүүлийн хагас жилд 1,323 хэлцэл хийгдэж 28.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татаж байсан бол 2023 оны эхний хагас жилд 1,011 хэлцлээр 36 тэрбум ам.доллар болж (АНУ-д 809 хэлцэл 34.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн) бусад гол бүс нутгуудын санхүүжилт мэдэгдэхүйц буурсан байна.

Зураг. Дэлхийн финтекийн салбарын хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо




Эх сурвалж: KPMG

Зураг. Дэлхийн финтекийн салбар дахь M&A /merge and acquisition/ хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: KPMG

Зураг. Дэлхийн финтекийн салбар дахь PE /private equity/ хөрөнгө оруулалтын нийт дүн, хэлцлийн тоо



Эх сурвалж: KPMG

Финтекийн зах зээл дэлхийн хэмжээнд 2023 оны эхний хагас жилд маш удаашралтай байсан тул олон хөрөнгө оруулагчид олон хүчин зүйлсийн улмаас хөрөнгө оруулахаас татгалзсан. Инфляц өндөр хэвээр, зээлийн хүү өссөөр, гарах гарц нь бүрхэг хэвээр байсан бөгөөд стартапын үнэлгээ буурахад ихээхэн дарамттай байсан тул хөрөнгө оруулагчид зохих шалгалтын процессоо сайжруулж, тогтвортой байдал, ашигтай бизнесийн загварт анхаарлаа хандуулав. Санхүүжилт нь тодорхойгүй, өрийн өртөг нэмэгдэж байгаа тул олон финтекүүд бүсээ чангалж, хямралыг даван туулах, хөрөнгө оруулагчдыг татахын тулд үйл ажиллагааны гүйцэтгэл, мөнгөн гүйлгээгээ сайжруулахад анхаарлаа хандуулав.

2023 оны сүүлийн хагас жилийн финтекийн салбарын анхаарах чиг хандлага:

- ◆ Финтекийн субвертикал, ялангуяа кибер аюулгүй байдал, баялгийн менежментийн технологи, инсуртек зэрэгт чиглэсэн хиймэл оюун ухааны шийдлүүдийн сонирхол, санхүүжилтийн хурдацтай өсөлт;
- ◆ Олон нийтийн зах зээлийн гүйцэтгэл хангалтгүй хэвээр байвал инсуртект нэмэлтээр хувийн хэдцлүүд хийх хандлага;
- ◆ Зөвхөн дэлхийн хэмжээнд төдийгүй эрх мэдлийн/зүйн хүрээнд болон бүс нутгийн хэмжээнд төлбөрийн орон зайг үргэлжлүүлэн нэгтгэх хандлага;
- ◆ B2B төвлөрсөн нэг цонхны платформууд болон хөгжиж буй зах зээл дэх хэрэглэгчдэд чиглэсэн B2C нэг интерфэйстэй супер аппликейшнд анхаарлаа хандуулж байна;
- ◆ Хуваагдсан/задархай санхүүжилтийн шийдлүүдийн тусламжтайгаар төрөл бүрийн хөрөнгийн ангилалд нэвтрэх эрхийг
- ◆ ардчилсан (нийтийн) болгох хандлага.

СУДЛААЧИЙН ИНДЭР

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын Сэндбоксын албаны дарга Б.Батчимэг batchimeg_b@frc.mn
Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын Сэндбоксын албаны мэргэжилтэн Б.Даваамаа davaamaa@frc.mn

УДИРТГАЛ

Платформоор дамжуулан олон тооны хөрөнгө оруулагчдаас бага хэмжээний дүнтэй мөнгийг татах замаар аливаа төсөл бизнесийг санхүүжүүлэх, түүнийг зуучлах санхүүжилт зуучлалын үйл ажиллагааг краудфандинг буюу хамтын санхүүжилт гэнэ. Хамтын санхүүжилтийн хэд хэдэн загвар байдаг бөгөөд тэдгээрийг ерөнхийд нь хандив, шагнал/урамшуулал, хөрөнгө оруулалт, зээлд суурилсан хамтын санхүүжилт гэсэн 4 төрөлд ангилдаг. Хандивт суурилсан хамтын санхүүжилтийн хувьд хандивлагч нь зуучлагч платформоор дамжуулан ашиг болон урамшуулал хүлээхгүйгээр төсөлд мөнгө хандивладаг бол шагнал/урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн хувьд хөрөнгө оруулагчид платформоор дамжуулан бүтээгдэхүүн, үйлчилгээний хөнгөлөлт, урамшууллыг авах зорилгоор аж ахуйн нэгж/төсөлд хөрөнгө оруулах боломжтой. Харин хөрөнгө оруулалтад суурилсан хамтын санхүүжилт гэж хөрөнгө оруулагчид зуучлагч платформоор дамжуулан хувь хүмүүс эсвэл байгууллагууд, түүний бизнесийн төсөлд тухайн байгууллагын хөрөнгөөс хувь хүртэх зорилгоор хөрөнгө оруулалт хийхийг хэлдэг бол зээлийн хамтын санхүүжилт нь хувь хүн, эсхүл аж ахуй нэгж P2P платформоор дамжуулан хэрэглээний болон бизнесийн төсөлд хүү амлаж зээлдүүлэгчээс санхүүжилт авахыг хэлдэг.

Судлаачид краудфандингийн хөгжлийн хурдацтай өсөлтийг Веб 2.0-ийн технологийн шинэчлэл болон 2007–2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас үүдэлтэй гэж үздэг. Санхүүгийн хямралын үед АНУ-ын Lehman Brothers банк дампуурсны дараа Европ, Хойд Америкт банкны зээл олголт зогсонги байдалд орсон. Үүнээс шалтгаалан жижиг, дунд бизнес эрхлэгчид (ЖДҮ) болон хувь хүмүүсийн санхүүжилт мэдэгдэхүйц буурч, улмаар санхүүжилт

босгох өөр арга хэрэгсэл болох хамтын санхүүжилтийн шинэ загварууд бий болж эхэлсэн(Hagedorn and Pinkwart 2013, 2016).

Краудфандинг нь ихэвчлэн гарааны бизнес болон ЖДҮ эрхлэгчид буюу бизнесийн хөгжлийн эхний үедээ байгаа компаниудад санхүүгийн эх үүсвэр татах хэрэгсэл болдог(Caroline Kleiner, 2021). Платформууд ил тод байдалд суурилсан гарааны бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан санхүүжилтийг амжилттай зуучилсан тохиолдолд гарааны бизнесийг бизнесийн хөгжлийн дараагийн шат руу хурдацтай шилжихэд тусалдаг. Гэсэн хэдий ч гарааны бизнес нь зах зээлд туршиж үзээгүй шинэ санаанаас бүрддэг учраас платформуудын хувьд гарааны бизнесүүдийн өсөж дэвших боломжтой эсэх, удирдлагын шударга байдал, бодит санаа, зөв менежменттэй байгаа эсэхийг бусдаас нь ялгахад хүндрэлтэй байдаг(Hatsuru et al. 2022). Иймээс олон улсын зохицуулагч байгууллагууд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах, ЖДҮ-ийг дэмжих зорилгоор хамтын санхүүжилтийн зуучлалын платформуудыг салбар болон тусгайлсан хуулиар зохицуулж байна. Харин Монгол Улсын хувьд хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь одоогоор эрх зүйн хувьд зохицуулалтгүй байгаа хэдий ч зах зээлд шинээр нэвтэрч буй тус үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хандив, урамшуулал, зээлд суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг сэндбоксын зохицуулалтын хүрээнд тодорхой хугацаа, бодит орчинд туршиж байна. Иймд энэхүү судалгааны ажлыг Монгол Улсад хамтын санхүүжилтийн олон улсын зохицуулалтын сайн туршлага, стандартыг нэвтрүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хийж гүйцэтгэлээ.

ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ТӨРЛҮҮД

1. ЗЭЭЛД СУУРИЛСАН ХАМТЫН САНХҮҮЖИЛТ

P2P зээл гэдэг нь хөрөнгө оруулагч, зээлдэгчдийг ямар нэгэн дундын зуучлагч банк, санхүүгийн байгууллагын оролцоогүйгээр цахим платформоор дамжуулан шууд холбох үйлчилгээ юм. P2P зээлийн үйлчилгээ нь хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны нэг төрөл бөгөөд уламжлалт бус санхүүгийн үйлчилгээнд (alternative financial services) хамаардаг. P2P зээл нь хөрөнгө оруулагчийн зээл автоматаар хуваарилагдан зээлийн хүсэлтийг санхүүжүүлэх, эсхүл хөрөнгө оруулагч өөрөө зээлдэгчээ сонгох гэсэн 2 үндсэн төрлөөр хийгддэг бөгөөд P2P зээлийн хүүг зээл хүсэгч, хөрөнгө оруулагч талууд хүүгээ санал болгох замаар тогтоох, эсхүл талуудыг зуучилж буй байгууллага зээлдэгчийн төлбөрийн чадамжийг үнэлэх замаар тогтоох боломжтой.

Их Британийн анхны P2P платформ болох “Zopa” байгуулагдсанаас хойш P2P зээл нь олон төрлийн бүтээгдэхүүнийг хамарч өргөжсөн. Үүнд барьцаа хөрөнгө, баталгаа шаарддаггүй бага дүнтэй хувь хүнд олгох зээлээс эхлэн жижиг, дунд бизнесийн зээл, бизнесийн нэхэмжлэхийн зээл, баталгаатай хувийн зээл, үл хөдлөх хөрөнгийн санхүүжилт, хөрөнгө худалдан авах, оюутны зээл гэх зэргээр хөгжиж байгаа бөгөөд P2P платформууд тодорхой төрлийн бүтээгдэхүүний чиглэлээр төрөлжих байдал нэмэгдсээр байна. P2P платформууд зээлийн бүтээгдэхүүний хувьд хүү тогтоох янз бүрийн аргуудыг ашигладаг. Жишээлбэл, санхүүгийн байгууллагуудын уламжлалт аргаар платформ дээрх бүх зээлд нэг хүүг тооцох эсвэл зээлдэгчийн зээлжих зэрэглэлд тулгуурлан өөр өөр хүү ногдуулах гэх мэт. Австралийн “SocietyOne” платформ нь зээлийн хүүгээ тогтоохдоо эрсдэлд суурилсан хандлагыг баримталж, зээлдэгчдэд “Зээлийн эрсдэлийн ангилал AA–аас D хүртэл байх ба хүүг буурах шатлалтайгаар” тооцдог. Өөрөөр хэлбэл, хүүгийн түвшин нь зээлийн зэрэглэлтэй холбоотой ба эрсдэл өндөртэй зээлд илүү өндөр хүү ногдуулна.

Зээлд суурилсан хамтын санхүүжилтийн ирээдүйн чиг хандлага:

Дэлхий даяар байгууллагын хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор P2P зах зээлийг сонирхож буй хөрөнгө оруулагчдын төрөл өөрчлөгдөж байна. Байгууллагын хөрөнгө оруулагчид уг платформыг ашиглан P2P платформд хөрөнгө оруулалт хийн зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж эхэлсэн. Энэ хандлага нь зөвхөн АНУ, Их Британид төдийгүй Австралид ч ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн хөрөнгө оруулагчид P2P салбар руу орж ирэх хандлагатай байгаа

юм. Их Британийн зохицуулагч байгууллага нь байгууллагын хөрөнгө оруулагчид P2P платформыг ашиглах нь нэмэгдэж буйг мэдэгдсэн ба Их Британид P2P хэрэглээний зээлийн 32 хувь, P2P бизнесийн зээлийн 26 хувь нь байгууллагын хөрөнгө оруулагчдаас санхүүжиж байна.

Зээлд суурилсан хамтын санхүүжилтийн тулгамдаж буй бэрхшээлүүд

Зохицуулалтын асуудал: P2P зээлийн хөрөнгө оруулагчид болон зээлдэгчдэд тулгамдаж буй нэг гол асуудал нь P2P зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулалт байдаг. Олон улсад P2P зээлийн зохицуулалт хэдхэн жилийн хугацаанд мэдэгдэхүйц сайжирсан боловч P2P зээлийг зохицуулахад чиглэсэн зохицуулалтын хариу арга хэмжээ нь улс орнуудад ихээхэн ялгаатай байна.

АНУ–ын хувьд P2P зээлтэй холбоотой хөрөнгө оруулалт хийх тал нь Үнэт цаасны хороо (SEC)–ны хяналтад байдаг бол зээл авах тал нь Хэрэглэгчийн санхүүг хамгаалах хороо болон Худалдааны хорооны хяналтад байдаг. Харин Их Британийн Санхүүгийн зохицуулагч байгууллага (FCA) нь P2P платформыг төслийн үнэлгээний байгууллага гэж үзэн, хөгжиж буй P2P салбарт инновац нэвтрүүлэх боломжийг олгох үүднээс илүү хөнгөн зохицуулалтыг чухалчилдаг.

Хятад улсын хувьд 2015 оноос өмнө P2P платформууд зохицуулалтгүй байсан. Энэ нь инновацыг бий болгож, зах зээлийн өсөлтийг хурдасгасан. Засгийн газар зах зээлийг зохицуулалтгүй байлгахыг зөвшөөрсөн нь хөрөнгийн зах зээл хөгжих боломж бий болно гэж үзсэнтэй холбоотой. Гэсэн хэдий ч энэ салбарыг удирдаж буй төрийн хяналт, зохицуулалт бага байсны үр дүнд салбарын буруу менежмент, зах зээлийн хүндрэл аажмаар нэмэгдсэн. Хятад улс P2P үйлчилгээ үзүүлэгчийг зах зээлийн хамгийн том сорилт гэж тодорхойлсон байдаг. P2P зах зээл нь Понзи маягийн бүтцийг бий болгож, улмаар зохицуулалтгүй P2P зах зээлд ихээхэн хүндрэлийг бий болгосон. Гэсэн хэдий ч 2015 онд Хятадын Ардын банк “Интернэт санхүүгийн эрүүл хөгжлийг дэмжих удирдамж”–ийг танилцуулснаар Хятадын Банкны Зохицуулах Хороо (CBRC) хяналт тавьж эхэлсэн. Хэдийгээр ийм удирдамжийг хууль эрх зүйн хувьд заавал дагаж мөрддөггүй боловч ирээдүйн хууль тогтоомжийн суурь хүрээг бий болгож, 2016 онд Хятадын Банкны Зохицуулах Хороо нь баталгаат өгөөжийг хориглох тухай багц зохицуулалтыг баталсан.

Харин Япон Улсын Санхүүгийн зохицуулагч байгууллага (FSA) нь P2P салбарын хуулийн хэрэгжилтэд шалгалт хийж, хяналт тавьдаг ба Японы хамтын санхүүжилтийн хууль нь платформ дээр хөрөнгө оруулагчдад батлан даалт өгөхийг хориглодог. Мөн хөрөнгө оруулагчдыг хамгаалахын тулд P2P платформуудыг доод тал нь таван сая иентэй байх, үйл ажиллагаа явуулах боломжтой байх, дагаж мөрдөх удирдамж, ажилтнуудтай байх, зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдал, хяналт шалгалтыг зохих журмын дагуу хийх, бизнес төлөвлөгөө боловсруулж, эрсдэл, хураамж болон бусад холбоо барих мэдээллийн ил тод байдлыг хангахыг шаарддаг. Японы P2P зээлийн зах зээлд үйл ажиллагаа явуулах, дагаж мөрдөх зардал өндөр байгаа нь уг салбарын гол асуудал юм. Учир нь зээл олгохын тулд платформууд Япон дахь Мөнгөн зээлийн хуулийн дагуу мөнгө зээлдүүлэгчийн лиценз/ тусгай зөвшөөрлийг баталгаажуулах шаардлагатай ба уг хуулийн дагуу зээлдэгчийн хувийн нууцыг хадгалах шаардлагатай байдаг ч нөгөө талаас Санхүүгийн хэрэгсэл ба биржийн тухай хуульд хөрөнгө оруулагчдыг хамгаалахын тулд зээлдэгчийн мэдээллийг ил тод болгохыг шаарддаг. Японы зах зээлд нэвтэрч буй P2P платформууд бизнес эхлэхээсээ өмнө мөнгө зээлэх, санхүүгийн хэрэгсэлтэй харьцах тусгай зөвшөөрөл авах ёстой байдаг ба энэ

нь шинэ компаниудыг зах зээлд нэвтрэхэд гол бэрхшээл болдог.

Луйвар ба P2P платформууд: P2P зах зээл дээр тулгардаг хамгийн хэцүү асуудлуудын нэг бол залилан мэхлэлт юм. Учир нь P2P зээл барьцаагүй зээл байдаг тул төлбөр төлөхгүй байх нь томоохон асуудал болох магадлалтай. Зээлдүүлэгч нь зээлдэгчийн эсрэг хуулийн дагуу арга хэмжээ авч, төлөх ёстой мөнгөө авах боломжтой хэдий ч P2P зээл нь бага хэмжээний зээлээс бүрддэг учраас зээлдүүлэгчдийн төлбөрийн гүйцэтгэлийг хангуулах зардал нь зээлийн дүнгээс хамаагүй өндөр байдаг. Мөн залилан хийх зорилготой байгуулагдсан платформууд байдаг бөгөөд зээлдүүлэгчдээс их хэмжээний мөнгө цуглуулсны дараа ихэвчлэн алга болдог. Үүний нэг жишээ нь P2P зээлийн зах зээлийн хэмжээгээрээ дэлхийд тэргүүлдэг Хятад улс юм. 2016 онд Хятадын P2P зах зээл дээр нэлээд олон дефолт гарсан нь хөрөнгө оруулагчид P2P зах зээлээс хөрөнгөө татахад хүргэсэн байна. 2016 оны 6 сар гэхэд 4127 P2P зээлийн платформуос 1778 нь дампуурах эрсдэлд орсон тухай мэдэгдэл гарсан бөгөөд Хятад дахь алдартай P2P платформуудын нэг болох Ezubao нь 900,000 орчим хөрөнгө оруулагчдаас багадаа 50 тэрбум юанийг луйвардсан Понзи схем болох нь тогтоогдсон.



P2P зээл ба технологи: P2P платформ нь Интернет болон санхүүг хослуулсан бизнесийн загвар бөгөөд технологид суурилсан систем тул боломжуудын хажуугаар олон тооны хүндрэл мөн үүсдэг. P2P зээлийн зээлийн үйл ажиллагааны үйл явц нь уламжлалт үйл явцтай бараг ижил хэдий ч P2P зээл олгоход хөрөнгө мөнгө, гэрээ хэлцэл, мэдээллийн журам зэрэг зээлийн үйл явц бүрэн цахимаар явагддаг.

Бүрэн цахим хэлбэрээр ажиллах нь зээл олгох үйл явц илүү хурдан, илүү ил тод, үйл ажиллагааны зардал багатай зэрэг уламжлалт санхүүгийн байгууллагуудаас давуу байдлаар зээл олгох боломжийг олгодог. Зарим P2P зээлдүүлэгчид платформд залилан илрүүлэх хиймэл сургалт, машин сургалтын дэвшилтүүдийг оруулсан байна. Гэсэн хэдий ч P2P зээлийн платформууд нь ихэвчлэн (харьцангуй) бага төсөвтэй байдаг тул P2P зээлийн платформууд нь хакердуулах, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлтэй тулгардаг.

Мэдээллийн тэгш бус байдал ба муу сонголт: Зээлийн зах зээл дэх мэдээллийн тэгш бус байдал, муу сонголтыг бууруулахын тулд батлан даалт гаргуулах, эсвэл хөрөнгийн барьцаа авах зэрэг хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой. Арилжааны банкнуудын хувьд (эсвэл бусад зээлийн байгууллага) зээлдэгчийн зээлийн зохистой байдлын талаар бодитой мэдээлэл олж авахын тулд цалингийн дэлгэрэнгүй мэдээллийг асууж, зээлийн мэдээллийг хариуцдаг байгууллагаас лавлаж болно. Гэсэн хэдий ч P2P зээлийн хувьд бүх зүйл өөр байдаг. Учир нь P2P платформын бүх зээлдэгч болон зээлдүүлэгчид нэрээ нууцалдаг тул зээлдүүлэгчид зээлдэгчийн хувийн мэдээлэл, орлого, зээлийн түүхийн талаар бүрэн бөгөөд үнэн зөв мэдээлэл авч чадахгүй. Энэхүү мэдээллийн тэгш бус байдал нь зээлдүүлэгчдийг зээлийн залилан мэхлэлтэд өртөх магадлалыг нэмэгдүүлдэг. Эдгээр сул талууд дээр нэмээд ихэнх улсуудад P2P зээлдэгчдийн зээлийн түүхийг тайлагнах улсын хэмжээнд зээлжих зэрэглэлийн систем хараахан байхгүй байна. Ийм тогтсон, найдвартай үнэлгээний механизм байхгүй байгаа нь ихэнх P2P платформуудын хувьд томоохон бэрхшээл болдог. Хэдийгээр зарим платформууд зээлдэгчийн ажил мэргэжил, орлогын эх үүсвэр, зээлийн зохистой байдлыг нягт нямбай шалгах замаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхийн тулд хүчин чармайлт гаргадаг ч эдгээр үйл явц нь ихэвчлэн гар аргаар явагддаг бөгөөд алдаа гарах магадлал өндөр байдаг. Тиймээс зээлдэгчид бүртгэлээ хуурамчаар үйлдэж, зээлдүүлэгчдийг зээлээ санхүүжүүлэхэд ятгахын тулд төөрөгдүүлсэн эсвэл худал мэдээллийг ашиглах боломжтой.

2. УРАМШУУЛАЛД СУУРИЛСАН ХАМТЫН САНХҮҮЖИЛТ

Урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн хувьд платформоор дамжуулан зах зээлд санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төслийг танилцуулснаар хөрөнгө босгогч өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үр дүнтэй сурталчилж, зах зээлийн хэмжээг урьдчилан хэмжих боломжтой ба уг санхүүжилт зуучлалаар ямар ч төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд зориулж санхүүжилт татах боломжтой байдаг. Энэ нь уг компанийн хувьд борлуулалтын хэрэгсэл болон сурталчилгааны хэрэгсэл болдог байна.

Урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн ирээдүйн чиг хандлага: Дээр дурдсанчлан урамшуулалд суурилсан хамтын санхүүжилт нь зөвхөн хөрөнгө босгох платформ бус цаашлаад зар сурталчилгааны хэрэгсэл болдог төдийгүй зах зээлийн хэмжээг урьдчилан тооцоолох боломжийг олгодог тул урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтээр хөрөнгө босгох хандлага сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна.

Урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн тулгамдаж буй бэрхшээлүүд: Урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн гол асуудал бол төслийн ивээн тэтгэгч болон хэрэглэгчдийн хоорондох мэдээллийн тэгш бус байдал юм. Төслийн ивээн тэтгэгчид урамшууллын бүтээгдэхүүний гүйцэтгэл, инновац, функциональ байршил, боломжит гэмтлүүдийн талаар мэдээллийг төсөл хэрэгжүүлэгч өгдөг бол бусад хэрэглэгчдийн хувьд бүтээгдэхүүн дээр гарч болзошгүй худал сурталчилгааны талаар олж тогтооход бэрхшээлтэй байдаг. 2015 онд гарсан Big Cola гар утасны хэрэг Хятадын нийгмийн анхаарлыг урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтэд татсан. 2015 онд 18,543 санхүүжүүлэгч Big Cola гар утасны хамтын санхүүжилтэд оролцож, нийтдээ 16,812,300 юанийн хөрөнгө оруулалт хийсэн. Гэрээнд зааснаар хамтын санхүүжилтийн төсөл албан ёсоор дууссаны дараа эхний ээлжийн 10,000 санхүүжүүлэгчид жил бүр гар утас үнэгүй авч, Big Cola гар утасны төслийн үйл ажиллагаанд оролцох байсан. Гэсэн хэдий ч төсөл дампуурч, төсөл хэрэгжүүлэгчид амлалтаа биелүүлээгүй учраас санхүүжүүлэгчид утсаа авч чадаагүй байна. Энэ тохиолдол нь хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны платформын хариуцлагын тодорхой бус байдлыг илчилсэн.

3. ХАНДИВТ СУУРИЛСАН ХАМТЫН САНХҮҮЖИЛТ

Хандивт суурилсан хамтын санхүүжилтийн хувьд хандив босгогч платформоор дамжуулан төсөл санал болгож хандивлагчдаас хандив босгодог. Хандивын хамтын санхүүжилтээр дамжуулан хандив өргөсөн хандивлагчид нь мөнгөн болон материаллаг өгөөж хүртдэггүй бөгөөд хандив босгогч нь хандивын зарцуулалтыг платформоор дамжуулан илтөд байдлаар хандивлагчид тайлагнах үүрэг хүлээдэг. Ийнхүү хандивлагчид өөрсдийн хөрөнгө оруулсан төсөл амжилттай болж, бусдад болон нийгэмд тусалсан гэдгээ бататгаснаар сэтгэл ханамжаа нэмэгдүүлдэг. Харин зуучлагч хамтын санхүүжилтийн платформ нь хандивын тодорхой хувийг үйлчилгээний хураамж болгон авсны дараа хандив босгогчид хандиваар цуглуулсан санхүүжилтийг хүлээлгэн өгдөг.

Хандивын хамтын санхүүжилтийн платформын төрлүүд

Хувийн болон эмнэлгийн тусламж: Хувийн болон эмнэлгийн яаралтай тусламжийн улмаас эмнэлгийн зардал, яаралтай мэс засал, оршуулгын зардал эсвэл бусад яаралтай хэрэгцээг хангах шаардлагатай санхүүгийн хүндрэлтэй тулгарсан хүмүүс ихэвчлэн энэ чиглэлд үйл ажиллагаа явуулдаг хандив цуглуулах төрийн бус байгууллага, эсхүл хандивын платформд ханддаг.

Ашгийн бус байгууллагууд: Буяны байгууллага болон ашгийн бус байгууллагууд өөрсдийн төсөл, хөтөлбөрт зориулж санхүүжилт босгохын тулд хандивын хамтын санхүүжилт ашигладаг. Эдгээр төсөл хөтөлбөр нь боловсрол, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, гамшгийн тусламж, амьтдын халамж зэрэг тодорхой асуудалд төвлөрдөг.

Олон нийтийн төсөл: Хандивын хамтын санхүүжилт нь тоглоомын талбай барих, нийтийн эзэмшлийн талбайг шинэчлэх, орон нутгийн арга хэмжээг санхүүжүүлэх, олон нийтийн төвүүдийг дэмжих зэрэг олон нийтэд түшиглэсэн янз бүрийн төслүүдийг дэмжих боломжтой. Эдгээр санаачилгууд нь тухайн бүс нутгийн оршин суугчдын амьдралын чанарыг сайжруулах зорилготой юм.

Боловсрол ба тэтгэлэг: Оюутнууд болон боловсролын байгууллагуудад туслах зорилгоор олон үйл ажиллагаа, хөтөлбөрийг зохион байгуулдаг. Эдгээр үйл ажиллагаа нь амьжиргааны түвшин доогуур оюутны сургалтын тэтгэлэг, сурагчийн хичээлийн хэрэгслийг санхүүжүүлэх, боловсролын хөтөлбөрт сайжруулалт хийх, нийгмийн боловсролын түвшнийг дээшлүүлэх зорилготой.

Олон нийтийг соён гэгээрүүлэх: Зарим байгууллага хандивын хамтын санхүүжилтийн платформоор дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, хүний эрх, жендерийн тэгш байдал, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, шударга ёс болон нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн аливаа үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд таниулах, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хандивын санхүүжилтийг босгодог.

Байгалийн гамшиг ба хүмүүнлэгийн тусламж: Байгалийн гамшиг тохиолдох эсвэл хүмүүнлэгийн хямрал тохиолдоход хандивын хамтын санхүүжилт нь дэлхийн өнцөг булан бүрд байгаа хүмүүст тусламжийн үйлсэд хувь нэмрээ оруулах боломжийг олгодог. Эдгээр ажил нь байгалийн гамшигт өртсөн бүс нутгуудад хоол хүнс, цэвэр ус, орон байр, эмнэлгийн тусламж, эрэн хайх, аврах ажилд туслах болон бусад чухал нөөцөөр хангахад тусалдаг.

Хандивын хамтын санхүүжилтэд тулгамдаж буй бэрхшээлүүд:

Хандивт суурилсан хамтын санхүүжилтэд түгээмэл 3 асуудал тулгардаг. Нэгдүгээрт, хандивын краудфандинг платформ дээр залилан мэхлэх, завших. Хандив босгогч хандивлагчдаас цуглуулсан хөрөнгөө зориулалтын бусаар ашиглаж хандивлагчийн платформд итгэх итгэлийг бууруулж, боломжит хандивлагчдын тоог бууруулах, хуурамч төсөл хөтөлбөрт санхүүжилт босгох эрсдэлийг үүсгэдэг. Хоёрдугаарт, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн платформуудын хоорондох ширүүн өрсөлдөөн. Зах зээл дээрх хандивын платформуудын хамтын санхүүжилтийн төслүүдийн төлөөх өрсөлдөөн нь хандивт суурилсан хамтын санхүүжилтийн төслөөр дамжуулан аль болох их хэмжээний мөнгө авахын тулд хамтын санхүүжилтийн платформууд өөрсдийн урьдчилсан шалгалтын стандартыг сулруулах, эсвэл бүр худал мэдээллийг зориудаар олон нийтэд хүргэдэг. Гуравдугаарт, хандивт суурилсан хамтын санхүүжилтээр хөрөнгө босгохыг оролдож буй хандив цуглуулагч нь хандивлагчдыг бусад төрлийн хамтын санхүүжилтээс илүү болгоомжтой ятгах шаардлагатай байдаг. Учир нь хандивлагч нь бусад хамтын санхүүжилтийн хөрөнгө оруулагчтай харьцуулахад ямар нэг урамшуулал, өгөөж хүртдэггүй. Тиймээс хандивын хамтын санхүүжилт нь бусад төрлийн хамтын санхүүжилт шиг түгээмэл бус байдаг.



ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ТАЛААР ТАНЫ МЭДЭХ ЁСТОЙ ЗҮЙЛС



**ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ**
/ УИХ-аас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр/



ВИРТУАЛ ХӨРӨНГӨ = Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгөнөөс бусад дигиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэнийн дигитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгө.



ХАРИЛЦАГЧ = виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс үйлчилгээ авч байгаа этгээд.

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА =

- ВИРТУАЛ ХӨРӨНГӨ, АЛБАН ЁСНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ ХООРОНД АРИЛЖИХ;
- НЭГ БОЛОН ОЛОН ТӨРЛИЙН ВИРТУАЛ ХӨРӨНГИЙГ ХООРОНД НЬ АРИЛЖИХ;
- ВИРТУАЛ ХӨРӨНГИЙГ ШИЛЖҮҮЛЭХ;
- ВИРТУАЛ ХӨРӨНГӨ, ТҮҮНД ХАМААРАХ ХЭРЭГСЛИЙГ ХАДГАЛАХ, УДИРДАХ;
- ВИРТУАЛ ХӨРӨНГИЙГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ, ХУДАЛДАХТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ БОЛОН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ.





САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Цуврал № 29

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ГҮЙЛГЭЭНИЙ ЯВЦ:

1



Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн цахим хуудсанд эсхүл програм татаж нэвтрэх;

2



Бүртгэл хийх, баталгаажуулж өөрийн харилцах дансаа холбож виртуал данс үүсгэх;

5



Дижитал түрийвч дэх мөнгийг хадгалах, арилжаанд ашиглах;

4



Сүлжээн дэх гүйлгээг баталгаажуулах;

3



Дижитал түрийвчинд мөнгө байршуулах, виртуал хөрөнгийг худалдах, худалдан авалт, гүйлгээнд ашиглах, шилжүүлэх;

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БОЛ:



Хуулийн этгээд байна.

Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй.



Харилцагчтай үйлчилгээ үзүүлэх гэрээ, хэлцэл байгуулна.

Хуулийн этгээдийн дансандаа харилцагчийн мөнгөн хөрөнгийг байршуулна.



ГҮЙЛГЭЭ ХИЙХЭД АНХААР!!!

ВИРТУАЛ ХӨРӨНГӨ:




- мөнгө хэлбэрээр ашиглах боломжгүй;
- ханш ийг урьдчилан таамаглах аргагүй;
- үнийн савлагаа өндөр;
- биет хөрөнгөөр баталгааждаггүй;
- хөрөнгө оруулсан эрсдэлээ өөрөө хариуцна.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ.



Одоо дэлхийн эдийн засаг 2023 онд Fitch Ratings-ийн 6-р сард гаргасан Дэлхийн эдийн засгийн төлөв (GEO- June Global Economic Outlook)-д төсөөлж байснаас арай хурдан өсөх хандлагатай байгаа ч Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт гүнзгийрч байгаа нь Мөнгөний чангаралт АНУ болон Европын эрэлтийн төлөвт улам бүр дарамт учруулж байгаатай адил дэлхийн эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна. Fitch ratings (FR) 2023 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамаглалыг 0.1 хувиар нэмэгдүүлэн өөрчилж, 2.5 хувь болгон өсгөсөн нь 2023 онд АНУ, Япон болон Хятадыг эс тооцвол хөгжиж буй зах зээл (EM) гайхалтай тогтвортой өсөлттэй байдлыг харуулж байна. Мөн FR нь АНУ-ын өсөлтийг 0.8 хувиар өсгөж 2.0 хувь болгож, Японы өсөлтийг 0.7 хувиар дээшлүүлж 2.0 хувь болгож, EM-ийн өсөлтийг шинэчилсэн. Хятадын өсөлт 0.5 хувиар буурч

3.4% болсон. Гэхдээ FR нь 2024 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамаглалыг 0.2 хувиар бууруулж 1.9% болгосон. FR 2024 оны АНУ-ын урьдчилсан таамаглалыг 0.2 хувиар бууруулж 0.3%, Евро бүсийг 0.3 хувиар бууруулж 1.1% болгон, Хятадын өсөлтийг 0.2%-иар бууруулж 4.6% болон 3.0%-д хүрэхээр төсөөлжээ.

Эх сурвалж: www.fitchratings.com

УРАНЫ БАЯЖМАЛЫН ҮНЭ СҮҮЛИЙН 12 ЖИЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНД ХҮРЧЭЭ.

ЛОНДОН. /FT/. Ураны баяжмалын үнэ “Фүкүшима-1” атомын цахилгаан станцад осол гарснаас хойш буюу сүүлийн 12 жилийн дээд хэмжээнд хүрсэн тухай дүн шинжилгээний “Uranium Exchange Company” компани мэдээлжээ.

Тус компанийн мэдээлж байгаагаар, “цөмийн эрчим хүч сэргэсэн”-тэй холбоотойгоор өнгөрсөн сард ураны баяжмалын үнэ 12 хувиар өсч, нэг фунт буюу 0.45 кг баяжмал 65.5 ам.доллар болсон нь өмнөх жилийн оргил үзүүлэлтийг давжээ. Дэлхийн хэд хэдэн улс орны засгийн газар эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилгоор цөмийн эрчим хүчинд оруулах хөрөнгийг нэмэгдүүлэх, хуучирсан реакторуудын ашиглалтын хугацааг уртасгах оролдлого хийж байгаатай холбоотойгоор ураны баяжмалын эрэлт эрс нэмэгдсэн байна.



Ураны үнийн өөрчлөлт нь эрчим хүчний хамгийн чухал нүүрстөрөгчгүй эх үүсвэрийн хувиар цөмийн эрчим хүчийг сэргээх замд том алхам болж байна гэж салбарын шинжээчид үзэж байна.

Дэлхийн хоёр дахь том уран үйлдвэрлэгч Канадын “Сатесо” компанийн санхүү хариуцсан захирал Грант Исаак хэлснээр, дэлхийн улс орнууд одоо “цэвэр эрчим хүчийг чухалчилж, эрчим хүчний аюулгүй байдалд” гол анхаарал хандуулж байна.

“Ураныг 40 ам.доллороор, магадгүй 50, 60 ам.доллороор худалдаж авдаг байсан үе өнгөрсөн. Одоо бид үнийн шинэ босго тогтоох хэрэгтэй” гэж тэрбээр тэмдэглэжээ. “Ocean Wall” брокерын компанийн гүйцэтгэх захирал Ник Лоусон “геополитикийн нөлөөгөөр эрэлт, нийлүүлэлт улам тэнцвэргүй болж байгаатай холбоотойгоор” 2025 он гэхэд ураны баяжмалын спот үнэ 200 ам.долларт хүрч өсөхийг үгүйсгэхгүй байна.

Дэлхийн цөмийн нийгэмлэг (WNA) саяхан дэлхийн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд эзлэх цөмийн эрчим хүчний хувь



хэмжээ болон ураны эрэлтийн талаарх таамаглалаа шинэчилсэн байна. “WNA”-ийн тооцоолсноор 140 гаруй реактор урьд нь таамаглаж байснаас илүү удаан хугацаагаар ажиллах боломжтой бол 2040 он гэхэд 35 ГВт-ын хүчин чадалтай жижиг модульчлагдсан реакторууд ашиглалтад орсноор жилд 130 мянган тонн болж хоёр дахин нэмэгдэх ураны хэрэгцээг хангахын тулд шинэ уурхайнуудыг эзэмших шаардлагатай болно.

Эх сурвалж: Монцамэ

ЕВРОПЫН ТӨВ БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ДАХИН ӨСГӨЖЭЭ.



БРЮССЕЛЬ. /Reuters/. Европын Төв банк 2023.09.14 буюу Пүрэв гарагт бодлогын гол гурван хүүгээ 25 суурь нэгжээр өсгөлөө. Еврогийн бүсийн төв банк хүүгээ 10 дахь удаагаа дараалан өсгөх үү эсвэл өсгөхөө түр зогсоох уу гэдэг дээр шинжээчид санал зөрөлдөж байсан юм.

Гэхдээ тус банк шийдвэрээ танилцуулахдаа инфляцыг тогтоон барихын тулд бодлогын хүүг хангалттай өсгөсөн гэж үзэж байгаагаа дахин илэрхийлсэн нь хүүгийн түвшнийг өсгөхөө удахгүй зогсоож магадгүйг харуулж байна.

Инфляц хэдийгээр буурах хандлагатай байгаа боловч “хэт өндөр” хэвээр байх төлөвтэй байна гэж тус банкны мэдэгдэлд дурджээ. “Евростат” байгууллагаас гаргасан урьдчилсан тооцоогоор, еврогийн бүсийн инфляцын түвшин наймдугаар сард 5.3 хувьтай хэвээр байсан нь дунд хугацааны зорилтот 2 хувиас давсан хэвээр байгаа юм.

Эрчим хүчний үнэ өсөх хандлагатай байгаатай холбогдуулан Европын Төв банк еврогийн бүсийн инфляцын талаарх таамаглалаа энэ онд 5.6 хувь, ирэх онд 3.2 хувь болгон шинэчилжээ. Харин 2025 оны инфляцын таамаглалыг 2.1 хувь болгон бууруулсан байна.

Түүнчлэн зээлийн өртөг нэмэгдэж байгаагаас шалтгаалан эрэлт буурах, олон улсын худалдаа суларч байгаа зэргийг харгалзан тус банк эдийн засгийн өсөлтийн төсөөллөө мэдэгдэхүйц бууруулахаар шийдсэн байна. Тодруулбал, еврогийн бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 онд 0.7 хувь, 2024 онд 1.0 хувь, 2025 онд 1.5 хувиар өснө гэж таамаглажээ.


Эх сурвалж: Монцамэ

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,443.95 -9.58 (-0.22%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


33,116.12 -126.47 (-0.38%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,660.20 +7.26 (+0.09%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

13,678.19 -32.05 (-0.23%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн Зохицуулах Хороо



@FRC_of_Mongolia